

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-5

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 6-10

1.Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох тухай 6-8

2.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ 8

3.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 4 гишүүн 2024.05.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ 8-10

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны
05 дугаар сарын 31-ний өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 9 цаг 58 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Жавхлан;

Чөлөөтэй: Ц.Анандбазар, Ж.Батсуурь, С.Ганбаатар, Д.Өнөрболор,
Б.Чойжилсүрэн;

Эмнэлгийн чөлөөтэй: Г.Амартүвшин, Ш.Раднаасэд.

Нэг.Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох тухай

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд нэр дэвшигч Д.Загджав, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын даргаас Монгол Улсын Ерөнхий аудитороор Д.Загджавыг томилуулахаар нэр дэвшүүлсэн саналыг Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар танилцуулав.

Нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.

Г.Тэмүүлэн: Монгол Улсын Ерөнхий аудитораар Дэлэгийн Загджавыг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн Захиргааны газрын дарга О.Энхбаяр, мөн компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга У.Чинзориг нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 09 минутад хэлэлцэж дуусав

Гурав.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 4 гишүүн 2024.05.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн Захиргааны газрын дарга О.Энхбаяр, мөн компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга У.Чинзориг нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул байлцав.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Тэмүүлэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал.

Г.Тэмүүлэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 16^{1.5.5} дахь заалтын “чиг үүргээ” гэснийг “энэ хуульд заасан бүрэн эрхээ” гэж, 16^{1.17} дахь хэсгийн “алба нь” гэснийг “албатай байж болох бөгөөд ажлын алба нь” гэж тус тус өөрчилж, мөн хэсгийн “нарийн бичгийн” гэсний дараа “дарга” гэж нэмэх.

2.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбогдуулан зүйл, хэсэг, заалтын дугаарыг өөрчлөх, агуулга зарчмыг хөндөхгүйгээр үг хэллэг, найруулгын засвар хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

1.Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

2.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

3.“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын ““Төрийн албаны зөвлөлийн дарга” гэсний дараа” гэснийг болон мөн заалтын ““Төрийн албаны зөвлөлийн гишүүн” гэсний дараа” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	5
Бүгд:	11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

4.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

5.“Цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

6.“Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэм батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 21 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 10 цаг 19 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дүгээр сарын 31-ний өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
9 цаг 58 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. Хавдисламын Баделхан гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн, Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, Лхагвын Мөнхбаатар гишүүн, Салдангийн Одонтуяа гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Чимэдийн Хүрэлбаатар гишүүн, Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна.

Ингээд Байнгын хорооны хуралд Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирсэн тул Төсвийн байнгын хорооны 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1.Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Улсын Их Хурлын даргаас 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдөр саналаа ирүүлсэн байна. 2 дахь асуудал Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Засгийн газар 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг байна. 3.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд анхны хэлэлцүүлэг байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад саналтай гишүүд байна

уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Нэг.Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох тухай асуудлыг хэлэлцэж эхэлье. Монгол Улсын Ерөнхий аудитораар томилуулах тухай саналын талаар Монгол Улсын Их Хурлын дэд дарга Лхагвын Мөнхбат дарга танилцуулна. Мөнхбат даргын микрофоныг өгье.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны гишүүдийн амрыг эрвье. Улсын Их Хурлын даргын албан бичгийг танилцуулъя. Ерөнхий аудитораар томилуулах тухай Монгол Улсын Их Хурлын 2019 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 46 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхий аудитораар Доржсүрэнгийн Занданбатыг 6 жилийн хугацаатайгаар, хугацаагаар томилсон бөгөөд 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр өөрийнх нь хүсэлтийг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын ажлаас чөлөөлсөн.

Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албан тушаалд нөхөн томилогдсон этгээдийн бүрэн эрхийн хугацаа нь өмнөх албан тушаалтны бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байх зохицуулалттай бөгөөд нөхөн томилогдсон этгээд нь жил хүрэхгүй хугацаанд ажиллах юм. Дэлэгийн Загджав нь Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан тушаалыг эрхэлдэг бөгөөд холбогдох хуульд заасны дагуу Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа тул Төрийн албаны тухай хуульд заасан нөхөн томилох үлдсэн хугацаанд Монгол Улсын Ерөнхий аудитораар томилуулах саналыг танилцуулж байна. Байнгын хорооны гишүүдийг дэмжиж өгөхийг хүсье.

Г.Тэмүүлэн: Мөнхбат даргад баярлалаа. Монгол Улсын Ерөнхий аудитораар томилуулах тухай санал болон нэр дэвшигчээс асуулт асуулт асуух гишүүд байна уу? Асуулт, санал цуг

байгаа, та өгөх үү, тэгье. Баделхан гишүүнээр тасаллаа. Баделхан гишүүн. Асуулт асуух гишүүд байхгүй байгаа. Үг хэлэх гишүүд Баделхан гишүүн байгаа. Баделхан гишүүний микрофоныг өгье. Баделхан гишүүн.

Х.Баделхан: Энэ одоо болж байна уу? Баярлалаа. Загджав даргыг дэмжиж байгаа юм. Ер нь төрийн албанд олон жил ажилласан, орон нутагтаа ажиллаж байсан, тэгээд төрийн албаны ер нь бүх салбарт ажилласан туршилагатай хүн. Тийм учраас дэмжиж байгаа. Тэгээд төрийн хариуцлагатай алба хашиж байсан, Төрийн нарийн бичгийн дарга, дэд сайд, сая Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын даргыг ажлыг бол нэр төртэй гүйцэтгэсэн. Мэргэжлийн хувьд ч гэсэн инженер мэргэжилтэй, эдийн засагч мэргэжилтэй, хуульч мэргэжилтэй юм байна. Тийм учраас ажлын дадлага туршилагатай энэ ажил дээр тохирсон хүн энэ ажлыг бас сайн хийж чадна гэж ингээд үзэж байгаа.

Харин цаашидаа болбол энэ байгууллагын ажлыг энэ чинь төрийн ажлын санхүүжилтийн гүйцэтгэл болбол хараат бус хяналт тавих ёстой үүрэг хүлээсэн тийм байгууллага. Энэ байгууллагын ажлыг цаашидаа шинэ шатад гаргах талаар, ялангуяа энэ авлига хээл хахуулиас хол байх, тэгээд аудиторруудыг болбол чанаржуулах асуудал дээр цаашидаа анхаарч ажиллах нь зүйтэй гэсэн ийм саналтай байна. Дэмжиж байна.

Г.Тэмүүлэн: Баделхан даргад баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтыг явуулъя. Та бүхэнд санал хураалт явуулахын өмнө тогтоолын төслийг танилцуулъя. Монгол Улсын Ерөнхий аудитор томилох тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийг

үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

Монгол Улсын Ерөнхий аудитораар Дэлэгийн Загджавыг өмнөх албан тушаалтны бүрэн эрхийн үлдсэн хугацаагаар нөхөн томилсугай. Энэ тогтоолыг 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм Улсын Их Хурлын тогтоолын төсөл байна. Ингээд Монгол Улсын Ерөнхий аудитораар Дэлэгийн Загджавыг томилохыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулна. Санал хураалтыг явуулъя. Эхлээд туршилтынхаар нэг хийгээдэхье, нээрээ шинэ төхөөрөмж байгаа учраас эхлээд хуруугаа хийнэ, хуруугаа авна, зөвшөөрсөн гэдэг дээр дарна. Туршилтынх байгаа. Зөвшөөрсөн, татгалзсан гэж 2 байгаа. Пүрэвдорж гишүүн байгаа. Та нэг дахиад нэг туршиж үзэх үү, зүгээр үү? Дахиад нэг туршаад үзээдэхье. Туршилтын санал хураалт тест, хуруугаа хийнэ, тийм, үгүй гэхээр авна, зөвшөөрсөн нь гацчихлаа. Та гараа салгачих, тэгэх үү? Тэгье. Пүрэвдорж гишүүн горимын санал гаргая. Пүрэвдорж гишүүн микрофон.

Б.Пүрэвдорж: Энэ нэг шинэ төхөөрөмж тавьсан юм шиг байгаа юм. Би олон дахин хэлээд байгаа. Энийгээ нэг тодорхой болгоод, ажиллахад боломжтой болгочхооч. Хурууны хээ хийгээд зөвшөөрсөн, татгалзсан 2 юу гарч ирэх ёстой байхгүй юу сонголт. Тэр нь дэлгэц дээрээ гарч ирэхгүй байна. Тэгэхээр энэ яг энэ танхимд л энэ шинэ тоног төхөөрөмж туршаад байх шиг байгаа юм. Тийм учраас энэ төхөөрөмж нь, программ нь бүрэн ажиллахгүй байгаа тул гараар санал хураалт явуулах горимын саналтай байна. Санал хураалгаж өгнө үү.

Г.Тэмүүлэн: Пүрэвдорж гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Бүгд гараар яах нь байна, төхөөрөмж бүрэн ажиллахгүй байгаа учраас. 11 гишүүн ирц байгаагаас 6 гишүүн дэмжиж, горимын санал дэмжигдлээ. Ингээд горимын санал

дэмжигдсэн учраас Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэдэг Монгол Улсын Ерөнхий аудитораар Дэлэгийн Загджавыг томилохыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт, 11-ээс 6, 6 гишүүн дэмжлээ.

Ингээд Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох асуудлаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Баделхан дарга та танилцуулах уу? Тэгье, Пүрэвдорж гишүүн танилцуулъя. Пүрэвдорж гишүүнээр танилцуулъя. Ингээд 2 дахь асуудалдаа оръё. Загджав даргад баярлалаа.

10.07 цаг

Хоёр. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

2 дахь асуудалдаа орцгооё. Аж ахуйн нэгжийн орлогын татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг та бүхэнд тараасан байгаа. Эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, гаргах танилцуулгыг миний бие танилцуулчихъя.

Протоколд ажлын хэсгийнхнийг танилцуулаадахъя. Болдбаатарын Анхбаяр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Уранбаатарын Чинзориг Монгол газрын тос боловсруулах үйлдвэр компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга,

Очирын Энхбаяр Монгол газрын тос боловсруулах үйлдвэр компанийн захиргааны газрын дарга гэсэн ийм ажлын хэсгийн бүрэлдэхүүн өнөөдрийн Байнгын хуралдаанд оролцож байна. Ингээд хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооноос гаргах танилцуулгыг миний бие нэгдсэн хуралдаанд танилцуулчихъя. Ингээд хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

10.09 цаг

Гурав. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 4 гишүүн 2024.05.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн байгаа билүү? Байхгүй тийм ээ, окэй. Тогтвортой байдлын тухай хуулийн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж санал хураалтыг явуулъя.

Хуулийн төсөл 4 зүйлтэй байгаа. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулаад асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна. Надад нэг зарчмын зөрүүтэй санал байгаа. Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн. Зарчмын зөрүүтэй санал, Хүрэлбаатар байхгүй. Нээрээ энэ чинь гараараа шүү дээ. Нээрээ тийм. Төслийн 1. Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн. Санал хураалт явуулъя. 11 гишүүнээс 6 гишүүн дэмжсэн.

Мөнхбаатар дарга, Баделхан дарга б. б дэмжигдлээ.

2.Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулаад асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулаад асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна. 4 дүгээр зүйл дээр нэг санал байгаа. Энэ хуулийг 2024 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн. Санал хураалт явуулъя. 11-ээс Пүрэвдорж гишүүн, 7. 7 гишүүн дэмжлээ.

Найруулгын санал. 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 16¹.5.5 дахь заалтын “чиг үүргээ” гэснийг “энэ хуульд заасан бүрэн эрхээ” гэж, 16¹.17 дахь хэсгийн “алба нь” гэснийг “албатай байж болох бөгөөд ажлын алба нь” гэж тус тус өөрчилж, мөн хэсгийн “нарийн бичгийн” гэсний дараа “дарга” гэж нэмэх.

2.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбогдуулан зүйл, хэсэг, заалтын дугаарыг өөрчлөх, агуулга зарчмыг хөндөхгүйгээр үг хэллэг, найруулгын засвар хийх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн. Санал хураалт. Гишүүд, Хүрэлбаатар сайд. 11-ээс 7, 7. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн төслийн санал хураалт явуулж дууслаа.

Нэг.Төсвийн тогтвортой байдлын тухай, одоо хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг зүйл бүрээр нь уншиж санал хураалгая. Нэг.Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл 3 зүйлтэй. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна. Хуулийн төсөл Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хоёр.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл 2 зүйлтэй. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна. Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Гурав.Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр асуулт, саналтай гишүүд байна уу? Энэ санал чинь аль. Саналтай гишүүд алга байна? Надад нэг санал байгаа. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар. 1.Төслийн 1 дэх заалтын ““Төрийн албаны зөвлөлийн дарга” гэсний дараа” гэснийг болон мөн заалтын ““Төрийн албаны зөвлөлийн гишүүн” гэсний дараа” гэснийг тус тус хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн. Санал хураалт. Хүрэлбаатар сайд, Тогтохсүрэн гишүүн. 6 гишүүнээс, 11-ээс 6.

Дөрөв.Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Их хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

5.Цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүр батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Цалингийн

хэмжээг тогтоох итгэлцүүр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна. Цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

10.19 цаг

Ингээд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа гишүүддээ.

6.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэм батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэм батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэм батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:

ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

Хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаарх Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд миний бие танилцуулъя. Хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэж дууслаа. Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан байна. Ингээд Байнгын хороонд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал.

Тэгье. Протоколд суулгах 1 санал байгаа. Саяын Төсвийн тогтвортой байдлын тухай хуультай холбогдуулаад Өрийн удирдлагын тухай хуулийн, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн анхны хэлэлцүүлэг явагдсантай холбогдуулаад Өрийн удирдлагын тухай хуулийн 39.2.6-д заасан 6.2 гэснийг цаашид анхаарч өөрчлөх саналыг Засгийн газарт бас чиглэл болгох тогтоолын төслийг бас оруулж ирэх шаардлагатай байна. Энийг бас протоколд тусгуулж байна.

Байнгын хорооноос болохоор хууль нь батлагдаагүй учраас тогтоолын төслийг өөрчлөх санал оруулж ирж болохгүй байгаад байгаа. Ингээд эцсийн найруулга дээр анхааруулах ёстой байна.

